



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хангай сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2024/212-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.Open.audit.mn
Архангай аймаг
2024 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141
Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn
Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860
Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn
Аудитор А.Пүрэвцэцэг
Утас: 7033-3019
Цахим хаяг: Purevtsetsega@audit.gov.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2024.02.25 № 70

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд уг хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хангай сумын ЗДТГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Хангай сумын ЗДТГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

ЗДТГ-ын даргын шийдвэрээр цалингийн сангаас 7200.0 мянган төгрөгийг зориулалт бус зарцуулсан байна.

Энэхүү зөрчил нь Төсвийн тухай хууль болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан зааврыг зөрчсөн бөгөөд тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитын гол асуудал

"Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын дагуу тус байгууллагын албан хаагчдын үндсэн цалинг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс шинэчлэн баталжээ. Үүнтэй холбоотойгоор цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос 62 хувиар өссөн байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 үндсэн зорилтын хүрээнд 18 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргаас 90 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.БАЙГАЛМАА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон			/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	89,746,082.40	112,940,519.40
33	АВЛАГА		27,548,750.00
33500	Бусад авлага		27,548,750.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага		27,548,750.00
35	БАРАА МАТЕРИАЛ	41,734,582.40	44,566,769.40
35100	Түүхий эд материал	6,927,980.00	6,647,830.00
35110	Тусгай зориулалттай материал	6,660,980.00	6,380,830.00
35130	Эм боох материал	267,000.00	267,000.00
35400	Хангамжийн материал	25,836,602.40	28,948,939.40
35410	Бичиг хэргийн материал	2,148,400.00	2,886,650.00
35420	Аж ахуйн материал	23,107,752.40	25,362,052.40
35440	Түлш, шатах тослох материал	580,450.00	668,738.00
35450	Барилгын засварын материал		31,499.00
35600	Мал амьтад	8,970,000.00	8,970,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	48,011,500.00	40,825,000.00
36300	Тэжээлийн нөөц	48,011,500.00	40,825,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,353,836,169.04	2,485,561,198.68
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,353,836,169.04	2,485,561,198.68
39200	Биет хөрөнгө	2,274,564,169.04	2,406,289,198.68
39201	Барилга, байгууламж, орон сууц	621,454,970.76	916,938,005.76
39202	Хуримтлагдсан элэгдэл	-39,644,768.00	-58,063,611.80
39203	Авто-тээврийн хэрэгсэл	372,653,885.00	372,653,885.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-127,390,308.44	-168,720,512.88
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	100,037,897.10	103,517,597.10
39206	Хуримтлагдсан элэгдэл	-34,288,212.44	-65,490,204.62
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,998,750.00	19,998,750.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7,237,575.64	-10,706,380.40
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,739,793,525.25	1,764,673,121.25
39215	Хуримтлагдсан элэгдэл	-377,169,336.55	-474,866,792.73
39216	Дуусаагүй барилга, байгууламж	6,355,342.00	6,355,342.00
39300	Биет бус хөрөнгө	79,272,000.00	79,272,000.00
39301	Програм хангамж	2,650,000.00	2,650,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,650,000.00	-2,650,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	79,272,000.00	79,272,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,443,582,251.44	2,598,501,718.08
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,443,582,251.44	2,598,501,718.08
51	Засгийн газрын хувь оролцоо	2,443,582,251.44	2,598,501,718.08
51100	Засгийн газрын оруулсан капитал	353,817,116.23	353,817,116.23
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	353,817,116.23	353,817,116.23
51200	Хуримтлагдсан үр дүн	2,023,747,187.42	2,178,666,654.06
51210	Өмнөх үеийн үр дүн	1,645,843,368.38	2,023,747,187.42
51220	Тайлант үеийн үр дүн	377,903,819.04	154,919,466.64
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	66,017,947.79	66,017,947.79
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,443,582,251.44	2,598,501,718.08

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	991,519,175.40	948,093,472.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	537,549,550.40	362,393,381.00
120	Нийтлэг татварын бус орлого	537,549,550.40	362,393,381.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	22,891,500.00	22,037,750.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	22,891,500.00	22,037,750.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	505,438,050.40	320,362,631.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	9,220,000.00	19,993,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	453,969,625.00	585,700,091.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,818,425.00	4,160,091.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	504,000.00	1,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,314,425.00	2,660,091.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	452,151,200.00	581,540,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	452,151,200.00	581,540,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	613,615,356.36	793,174,005.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	613,615,356.36	793,174,005.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	563,094,343.36	757,115,071.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	245,879,222.00	398,091,414.00
210101	Үндсэн цалин	206,526,526.00	291,797,376.00
210102	Нэмэгдэл	35,142,193.00	81,365,559.00
210104	Урамшуулал	4,210,503.00	16,739,432.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	8,189,047.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,705,878.00	50,682,426.00
210201	Тэтгэврийн даатгал	20,880,271.00	34,463,974.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,456,401.00	4,054,639.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,965,481.00	3,314,576.00
210204	Ажилгүйдлийн даатгал	490,917.00	739,960.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,912,808.00	8,109,277.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,128,692.00	13,642,209.26
210301	Гэрэл, цахилгаан	2,479,392.00	4,009,209.26
210302	Түлш, халаалт	10,604,000.00	9,588,000.00
210303	Цэвэр, бохир ус	45,300.00	45,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	35,375,797.00	42,798,612.60
210401	Бичиг хэрэг	5,107,300.00	3,628,950.00
210402	Тээвэр, шатахуун	15,659,846.00	27,621,097.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,439,745.00	4,489,123.60
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,253,156.00	4,583,892.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	915,750.00	2,475,550.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,000,300.00	10,202,091.00
210604	Урсгал засвар	13,000,300.00	5,324,991.00
2107	Томилолт, зочны зардал	14,136,000.00	17,108,200.00
210702	Дотоод албан томилолт	14,136,000.00	17,108,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,749,505.00	3,218,567.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	27,192,800.00	1,911,591.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	288,092.00	356,140.00

Архангай аймгийн Хангай сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.00	200,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	700,000.00
210807	Газрын төлбөр	18,613.00	50,836.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	183,118,949.36	221,371,551.36
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,701,588.00	23,419,250.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,014,000.00	5,835,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	149,403,361.36	192,117,301.36
212	ТАТААС	4,032,420.00	3,634,960.00
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	4,032,420.00	3,634,960.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	4,032,420.00	3,634,960.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,488,593.00	32,423,974.14
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,974,200.00	3,017,100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,924,900.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,049,300.00	3,017,100.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	31,514,393.00	29,406,874.14
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,514,393.00	29,406,874.14
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	377,903,819.04	154,919,466.64
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	377,903,819.04	154,919,466.64

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	478,453,125.00	607,737,841.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	24,483,500.00	22,037,750.00
120	Нийтлэг татварын бус орлого	24,483,500.00	22,037,750.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	24,483,500.00	22,037,750.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	24,483,500.00	22,037,750.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	453,969,625.00	585,700,091.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,818,425.00	4,160,091.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	504,000.00	1,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,314,425.00	2,660,091.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	452,151,200.00	581,540,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	452,151,200.00	581,540,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	468,603,225.00	604,258,141.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	468,603,225.00	604,258,141.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	417,406,712.00	567,459,706.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	245,969,500.00	398,091,414.00
210101	Үндсэн цалин	206,616,804.00	291,797,376.00
210102	Нэмэгдэл	35,142,193.00	81,365,559.00
210104	Урамшуулал	4,210,503.00	16,739,432.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	8,189,047.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,615,600.00	50,682,426.00
210201	Тэтгэврийн даатгал	20,818,595.00	34,463,974.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,449,251.00	4,054,639.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,959,401.00	3,243,669.00
210204	Ажилгүйдлийн даатгал	489,849.00	810,867.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,898,504.00	8,109,277.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,758,692.00	13,642,209.26
210301	Гэрэл, цахилгаан	2,479,392.00	4,009,209.26
210302	Түлш, халаалт	10,234,000.00	9,588,000.00

Архангай аймгийн Хангай сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210303	Цэвэр, бохир ус	45,300.00	45,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	33,364,527.00	35,792,295.60
210401	Бичиг хэрэг	4,124,800.00	4,032,400.00
210402	Тээвэр, шатахуун	14,375,158.00	18,525,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,407,245.00	4,489,123.60
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,483,524.00	7,232,372.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	973,800.00	1,513,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,132,300.00	10,749,990.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	1,014,000.00
210604	Урсгал засвар	13,132,300.00	9,735,990.00
2107	Томилолт, зочны зардал	13,900,000.00	17,108,200.00
210701	Гадаад албан томилолт	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	13,900,000.00	17,108,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,834,005.00	4,558,882.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	27,277,300.00	3,251,906.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	244,092.00	356,140.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	200,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	700,000.00
210807	Газрын төлбөр	18,613.00	50,836.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,832,088.00	36,834,290.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	38,582,088.00	30,999,290.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,250,000.00	5,835,000.00
212	ТАТААС	4,492,420.00	3,999,460.00
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	4,492,420.00	3,999,460.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	4,492,420.00	3,999,460.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,704,093.00	32,798,974.14
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,189,700.00	3,392,100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,924,900.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,264,800.00	3,392,100.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	31,514,393.00	29,406,874.14
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,514,393.00	29,406,874.14
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	9,849,900.00	3,479,700.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	9,849,900.00	3,479,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,849,900.00	3,479,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	9,849,900.00	3,479,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9,849,900.00	3,479,700.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-9,849,900.00	-3,479,700.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон					/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	353,817,116.23	66,017,947.79	1,648,461,055.13	2,068,296,119.15
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-2,617,686.75	-2,617,686.75

Архангай аймгийн Хангай сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	353,817,116.23	66,017,947.79	1,645,843,368.38	2,065,678,432.40
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	377,903,819.04	377,903,819.04
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	353,817,116.23	66,017,947.79	2,023,747,187.42	2,443,582,251.44
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	353,817,116.23	66,017,947.79	2,023,747,187.42	2,443,582,251.44
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	353,817,116.23	66,017,947.79	2,023,747,187.42	2,443,582,251.44
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	154,919,466.64	154,919,466.64
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	353,817,116.23	66,017,947.79	2,178,666,654.06	2,598,501,718.08

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	611,540,000.00	574,170,875.86	-37,369,124.14	93.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	611,540,000.00	574,170,875.86	-37,369,124.14	93.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	604,540,000.00	567,279,315.86	-37,260,684.14	93.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	406,121,500.00	398,091,414.00	-8,030,086.00	98.02
210101	Үндсэн цалин	400,015,900.00	291,797,376.00	-108,218,524.00	72.95
210102	Нэмэгдэл	0.00	81,365,559.00	81,365,559.00	100.00
210104	Урамшуулал	0.00	16,739,432.00	16,739,432.00	100.00
210105	Гэрээт ажлын хөлс	6,105,600.00	8,189,047.00	2,083,447.00	134.12
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,765,000.00	50,682,426.00	-82,574.00	99.84
210201	Тэтгэврийн даатгал	34,520,200.00	34,463,974.00	-56,226.00	99.84
210202	Тэтгэмжийн даатгал	4,061,200.00	4,054,639.00	-6,561.00	99.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,249,000.00	3,243,669.00	-5,331.00	99.84
210204	Ажилгүйдлийн даатгал	812,200.00	810,867.00	-1,333.00	99.84
210205	Эрүүл мэндийн даатгал	8,122,400.00	8,109,277.00	-13,123.00	99.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,389,900.00	13,642,209.26	-4,747,690.74	74.18
210301	Гэрэл, цахилгаан	5,000,000.00	4,009,209.26	-990,790.74	80.18
210302	Түлш, халаалт	13,189,900.00	9,588,000.00	-3,601,900.00	72.69
210303	Цэвэр, бохир ус	200,000.00	45,000.00	-155,000.00	22.50
2104	Хангамж, бараа материалын зардал	34,416,400.00	33,884,295.60	-532,104.40	98.45
210401	Бичиг хэрэг	4,000,000.00	4,032,400.00	32,400.00	100.81
210402	Тээвэр, шатахуун	16,617,400.00	16,617,400.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,600,000.00	4,489,123.60	-110,876.40	97.59
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,699,000.00	7,232,372.00	-466,628.00	93.94
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000.00	1,513,000.00	13,000.00	100.87
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,243,600.00	14,229,690.00	-13,910.00	99.90
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,500,000.00	4,493,700.00	-6,300.00	99.86
210604	Урсгал засвар	9,743,600.00	9,735,990.00	-7,610.00	99.92
2107	Томиллолт, зочны зардал	17,108,800.00	17,108,200.00	-600.00	100.00
210702	Дотоод албан томиллолт	17,108,800.00	17,108,200.00	-600.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,889,800.00	2,806,791.00	-7,083,009.00	28.38
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,889,800.00	1,499,815.00	-6,389,985.00	19.01
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	0.00	-500,000.00	0.00

Архангай аймгийн Хангай сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210804	Тээврийн хэрэгслийн татвар	500,000.00	356,140.00	-143,860.00	71.23
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	200,000.00	200,000.00	0.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	700,000.00	700,000.00	0.00	100.00
210807	Газрын төлбөр	100,000.00	50,836.00	-49,164.00	50.84
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53,605,000.00	36,834,290.00	-16,770,710.00	68.71
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	47,095,000.00	30,999,290.00	-16,095,710.00	65.82
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,510,000.00	5,835,000.00	-675,000.00	89.63
212	ТАТААС	4,000,000.00	3,999,460.00	-540.00	99.99
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	4,000,000.00	3,999,460.00	-540.00	99.99
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	4,000,000.00	3,999,460.00	-540.00	99.99
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,000,000.00	2,892,100.00	-107,900.00	96.40
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,000,000.00	2,892,100.00	-107,900.00	96.40
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000.00	2,892,100.00	-107,900.00	96.40
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	611,540,000.00	574,170,875.86	-37,369,124.14	93.89
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	517,717,000.00	552,133,125.86	34,416,125.86	106.65
320001	Орон нутгийн төсвөөс	517,717,000.00	552,133,125.86	34,416,125.86	106.65
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	93,823,000.00	22,037,750.00	-71,785,250.00	23.49
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	30,000,000.00	22,037,750.00	-7,962,250.00	73.46
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	63,823,000.00	0.00	-63,823,000.00	0.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	49.00	1.00	-48.00	2.04
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	24.00	0.00	-24.00	0.00
620001	Удирдах ажилтан	9.00	0.00	-9.00	0.00
620002	Гүйцэтгэх ажилтан	8.00	0.00	-8.00	0.00
620003	Үйлчлэх ажилтан	7.00	0.00	-7.00	0.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	24.00	0.00	-24.00	0.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9.00	0.00	-9.00	0.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7.00	0.00	-7.00	0.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	8.00	0.00	-8.00	0.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,160,091.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,160,091.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,660,091.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,908,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,908,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,752,091.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,752,091.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	500,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,160,091.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,908,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,252,091.00

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа¹ илрээгүй, харин залруулагдаагүй нийт 7,200.0 мянган төгрөгийн зөрчил² илэрсэнд зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх 1 албан шаардлага хүргүүллээ.

Аудитаар залруулагдаагүй 1 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь **7,200.0** мянган төгрөг бөгөөд тогтоосон материаллаг байдлын дүн **5,844.4** мянган төгрөгөөс их байгаа тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5.1 Албан шаардлага

5.1.1 ЗДТГ-ын газрын даргын 12 сарын 21-ны өдрийн А/24 дугаар тушаалаар 24 албан хаагчдад түлээ нүүрсний хөнгөлөлт 7,200.0 мянган төгрөгийг цалингийн сангаас олгосон байна.

Энэ нь Сангийн Сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын “Үндсэн цалин” (210101) “Цалингийн сүлжээ, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон бусад холбогдох эрх зүйн актын дагуу тогтоон олгож байгаа үндсэн болон байнгын гэрээт ажилтны албан тушаалын үндсэн цалин энэ ангилалд багтана. Ажилтны үндсэн ажлын зэрэгцээ мэргэжил албан тушаалын хавсран хослон гүйцэтгэсэн, эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгэсэн, ээлжийн амралтын олговор, сул зогсолтын үеийн олговор, хүндэтгэн үзэх шалтгаанаар ажилдаа ирээгүй үеийн олгох жирэмсэн болон амаржсаны тэтгэмж, хөдөлмөрийн чадвар түр хугацаагаар алдсаны ажлын эхний 5 өдрийн тэтгэмж энд хамаарна.” гэсэн заалтуудтай нийцэхгүй Төсвийн тухай хуулийн 16 зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүллээ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс											
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
ЗДТГ-ын газрын даргын 12 сарын 21-ны өдрийн А/24 дугаар тушаалаар 24 албан хаагчдад түлээ нүүрсний хөнгөлөлт 7,200.0 мянган төгрөгийг цалингийн сангаас олгосон байна.	1	7,200.0			1	7,200.0								
Дүн	1	7,200.0			1	7,200.0								

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

